

## АРДЫН ДҮРСЛЭЛИЙН ХЭЛ

Д.Батжаргал\*

\* МУИС, МХСС-ийн Утга зохиол судлалын тэнхимийн багш, доктор (Ph.D.)

**Түлхүүр үг:** Утга зохиолын хэлний хэм хэмжээ, дүрслэл, ардын сайхан яриа, сэтгүүлчдийн болон улс төрчдийн хэлний алдаа дутагдал

**А**рдынхаа хэлний яруу сайхан дүрслэл, урын сангаас манай сэтгүүлчид суралцахгүй байна. Суралцдаг сан бол хэчнээн сайхан уянгатай, уншууртай, "амттай" хэлээр ярьж, бичихсэн билээ. Манай их бичгийн хүн Чой.Лувсанжав багш Монголын радиогийн "Соёлч радио сонин" нэвтрүүлгийн эх хэлээ хайрлах сэдвийг хөндсөн 90-ээд оны цувралд өгсөн ярилцлагадаа:

- Монгол хэлээ сайжруулахын тулд эх хэлний хоёр ундаргаас ундаалах ёстой. Нэг дэх нь бичгийн сурвалж юм. Улсын архивт байгаа шавь дөрвөн аймгийн сайхан найруулгатай бүтээлээс монгол бичгээр уншвал ямар ч сэтгэлтэй сэтгүүлч, бичигч хүний хэл сайжирна. Нөгөө нь ардын хэл юм. Цэрэгт яваагүй өвгөчүүл, нутгаасаа гараагүй эмгэдээс суралцах ёстой гээд доорх жишээг дурдаж билээ.

Ринчен доктор 1964 онд Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр суманд шинжилгээний ангиар явж байжээ. Э.Вандуй, Чой.Лувсанжав нар хамт явж л дээ. Нэг айлд очоод гэрийн эзэнтэй хуучлаад сууж байтал гаднаас хажуу айлын

эмгэн орж ирээд эзэгтэйгээс "Энэ буурал толгойтой хүн хэн бугай вэ?" хэмээн асуужээ. Нэрийг нь хэлэнгүүт ханцуй дотроо залбиран "Шүдлэн настай байхдаа алдар сайхан нэрийг нь сонсож байлаа. Шүдээ унасан хойно гэгээн дүрий нь хардаг байжээ" хэмээн хэлсэн байгаа.

Өнөө бидний хэлээр бол залуу байхдаа нэрийг нь дуулж байлаа, хөгширсөн хойноо зүсий нь харлаа гэх молхи үгсийг шүлэг шиг сайхан яруу өгүүлж байна. Шүдлэн нас гэдэг мал аж ахуй эрхэлж ирсэн нүүдэлчдийн хэлэх үг. Гурван настай малд оноодог нэрийг хүншүүлэн өөртөө шингээн хэлэх нь ардын билиг хэллэг юм. Мөн Лувсанжав доктор нэгэн удаа нутагтаа очоод саахалт явсан айлынх нь хар хүн өнгөрснийг дуулаад, халгаж халгаж гэрийн эзэгтэйтэй уулзахад "Муу эгч нь уул шиг сайхан ханиа унагаад, улаан цурав хэдэн нялх хүүхэдтэй үлдлээ. Дээр нь та нар байна, доор нь бид нар байна. Тэгээд болно биз дээ" гэж хэлсэн байна. Ийм сайхан жишээ олныг өгүүлж болно.

Үгийг ганц ганцаар нь цуглуулж "богц дүүргэдэг", бичиг бүтээлдээ оруулан хэрэгцээ болгодог нь эрдэмтний, бичгийн хүний нөр хичээнгүй хөдөлмөр юм. Ринчен доктор дархадын нутгаар явж гайхалтай аялгатай үг олж ирсэн

тухай нэрт түүхч, эрдэмтэн О.Пүрэв нэгэнтээ ийнхүү ярьсан байна. "Ринчен гуай хаана л очно, тэнд хүмүүс цуглачихсан яриагий нь сонсож байна л даа. Нэг удаа Хөвсгөл үрүү явсан тухайгаа ярилаа. Манай нутгийн тухай юу гэж ярих бол гээд би чих тавьж зогсов. Рэнчинлхүмбэ орж, хойшоо явж Тэнгист очлоо. XIII зууны хэлний дурсгалт зүйл оллоо гэж байна. Би бичиг дурсгал олж дээ гэж бодлоо. Хүмүүс ч тэгэж бодож байсан бололтой "Хадны бичиг үү?" гэж асууж байна. Тэгсэн чинь "Амьд дурсгал" гэлээ. Юу хэлэв, долоон зуу гаруй жил болдог амьд дурсгал гэхээр санаанд багтахгүй байлаа. Тэнгист нэг эмгэн байна. Тэр хүн аймгийн төв орж үзээгүй. Бүр, сумын төв ч орж үзээгүй. Адаглаад, бригадын төв ч орж үзээгүй. Кирилл бичиг, монгол бичиг мэдэхгүй, нэг үгээр хэлбэл ертөнцийн бүх соёлоос тасарчихсан хүн байна. Тэр хүнээс эртний монгол хэлний хоёр үг сонслоо. "Ямар муухай юм бэ?" гэхийг "Ямар магухай юм бэ?" гэж хэлж байна. Бас сонсоод гэдгийг "сонсоод" гэж хэллээ. Энэ хоёр үг яах аргагүй XIII зууны аялгаараа дархдад хадгалагдсан байна гэж билээ"<sup>1</sup> хэмээн ярьсан байна.

Ерөөс хязгаар нутгаар хэлний аялга хадгалагдан, сондор мэт сайхан хэллэг, уран дүрслэл нуугдан үлдсэн байдгийг манай сэтгүүлчид уудлан гаргаж өнгөлөн зүлгэх мэт, нийтийн үг ярианд оруулж байвал үлэмж тустай биш үү. Цэцэн билигт дархад түмний Чанцалдулам хэмээх нэгэн эмэгтэй хэдийгээр ядуу татуухан тэнэмэл нэгэн байсан ч залуу насны хайр дурлалаас тойрсонгүй. Хүнд хайртай болж, түүндээ зориулан,

*Хэттэй цоохор домбыг нь*

*Сөгнөн суухын аврал*

*Хэттэй бэлтэй ташааг нь*

*Түшин суухын аврал*

*Хорол тоонотой өргөөндөө*

*Хоёулаа суухын аврал*

*Хотгор цоохор сарлагийг нь*

*Хотолж л явахын аврал*

гэж нэгэн үе дуулж байсан бол дараа нь,

*Домбын чинээн Донхжий нь*

*Дотроос гарахаа болилоо*

*Ханцуйн чинээн Донхжий нь*

*Хайраас гарахаа байлаа*

*Угжийн чинээн Донхжий нь*

*Ухаанаас салахаа болилоо*

хэмээсэн нь Донхжий гэдэг хүнд хайртай болж, сэтгэлийн шаналал эдлэн түүнээ хүсэж мөрөөдөж явахдаа ийм дуу зохиожээ.

Энд ардын дүрслэлийн олон сайхан жишээ харагдана. Сархад айргийг сөгнөдөг байтал домботой цай хүртэл аз жаргалын амт баланд согтуурдгийг энгийн хэлээр дүрслэн, хайртай болсон хүнээ хамгийн ойр дөт зүйлээр төлөөлүүлсэн нь ганган чамин бус атлаа эерүү зөөлөн дулаан зүйрлэл болжээ. Энд зохиогчийн олон хүсэл мөрөөдөл шингэж, "хот дүүрэн сарлаг", "хорол тоонотой гэр", "хэттэй бэлтэй ташаа" гээд мал сүрэг, гэр орон, хань ижил гээд дутуу гуцуу зүйлгүйгээр дүрслэн илэрхийлсэн байна.

Чой.Лувсанжав доктор "Хэл бол салхи, бичиг бол мөр" гэж дандаа хэлдэгсэн. Багшийнхаа сонссон дуулснаа үргэлж тэмдэглэн авч, өөриймшүүлэн ямагт хэрэглэж байхыг сургасан энэ сайхан афоризмыг олон оюутны дэвтэрт хэлж өгч бичүүлэн үлдээсэн атал тэднээс маань толгойдоо тогтоож ажил болгосон нь хэр болоо.

Тэмдэглэл ямар үнэ цэнтэй байдгийг сэтгүүлч бидэнд мэдрүүлсэн хүн Монгол улсын аварга Д.Хадбаатар юм. Түүний ховор нандин тэмдэглэлийг зохиолч З.Түмэнжаргал нар "Ням гариг"

сонинд хэдэн цувралаар нийтэлж уншигчдын хүртээл болгосон байна. Сонин өмнөх үгэндээ "Аварга маань үнэхээр харахад хээ шаагүй, салан задгай мэт хүн байсан ч өөрийн онож алдаж явсан амьдрал, орооцолдож ээдэрч асан хувь тавилангийнхаа талаар бас ч нарийн ширийн зүйлийг тэмдэглэн бичиж үлдээжээ" гээд олон тайлбаргүйгээр нийтэлжээ.

Тэмдэглэлд 19 насандаа БНМАУ-ын начин гэдэг эрхэм хүндэт цол хүртэх тавын даваанд Чойжилсүрэн арслантай барилдсан тухайгаа "Өрлөө, цэрвэж байгаа ч юм шиг. Элэг уяанаас нь барьж автал тасхийгээд явчихлаа. Барьсан чигээрээ суун тусаж барьцаа алдалгүй босож, айж байснаа мартаад, ачиж нэг үзээд, нохой мордох гэж ч нэг үзээд, зөндөө л мэхэрхүү юм хийсэн юм билээ. Би унагаж босгоод л өөрөө уначих шахаад л юу болсон ч юм мэдэхгүй ээ. Тэр үедээ би улайрчихсан юм билээ. Тэгээд санаснаараа элгэн дороо хийж аваад хэвтээд байсан чинь засуул ирээд татаж босгов. Миний хамраас цус гарч байна. Чойжилсүрэн арслан намайг үнсэж тахимаа өгөөд цаашаа очсон хойноо,

- Би мангар Санжаа, улаан Эрдэнэ-Очир нарын бянтай бөхчүүлтэй барилдаж болоод байдаг юмсан. Саяын амьтан чинь яг л адгуус шиг юм. Юутай барилдаж орхив оо. Би уналаа гээд биеэ сул орхитол нөгөө талдаа гаргаад тавьчих юм. Хамаг ясыг минь тараах шахлаа. Мөн ч аймшигтай бянтай юм гэж ярьсан гэдэг"<sup>2</sup> гэж бичжээ. Хэрвээ аварга маань тэмдэглэл хөтөлдөггүй-

сэн бол Чойжилсүрэнгийн амттай яриа бидэнд хүрч ирэх байсан болов уу. Уул мэт том, хүүхэд мэт гэнэн аваргын тухай ийм сайхан тэмдэглэл салхи мэт он цагийн шуурган эдгэрэн бүдгэрэх бус уу.

"Монгол нэвтрүүлгийн (радио, телевизийг хамтатган хэлж байна — Д.Б.) хэл, бичигч, зохиолчдын найруулга түг таг хийсэн модон хэлтэй байна. Үүнийг ажигласан цэцэн мэргэн нь би биш, гуч дөчин жилийн өмнөөс Ринчен доктор шүүмжлэн "Үг нь монгол, өгүүлбэр нь орос, үзэхэд этгээд "Үнэн" сонины хэл" гэж бичиж байлаа. Далаад оны үед тод бичгийн ой болж нэгэн хурал дээр МОНЦАМЭ-гийн хөгжмийн редактор Цоодол ардын сайхан

дуу дуулсан. Тэр хуралд оролцсон Ринчен доктор:

*"Модон хэлтэй МОНЦАМЭ-гийн дотор*

*Молор эрдэнэ шиг хүн байдаг юм байна гэсэн нь магтаал зэмлэлийг хослуулан эх хэлээ хайрлахыг сануулж байлаа"* хэмээн Лувсанжав багш ярьж билээ.

Эдүгээ сонин сэтгүүлийн хэл тарчиг ядуу, цөөхөн үгэнд эргэлдсэн модон мохоо бүү хэл, харь хэлний хачир чимэг ихтэй байгааг Ринчен доктор шиг үргэлж биш ч мэр сэр шүүмжлэн дуугардаг хүмүүс байна. Төгс Олхонуд Д.Данзан "Өнөөдөр" сонинд бичсэн өгүүлэлдээ<sup>3</sup>, сайд дарга нар, яруу тунгалаг хэлтэй байх ёстой яруу найрагч, сэтгүүлч сурвалжлагч, жирийн хүмүүсийн яриа бичигт нэлээд их ордог үгийг жишээ баримттай шүүмжлээд

«  
*Ерөөс хязгаар нутгаар хэлний аялга хадгалагдан, сондор мэт сайхан хэллэг, уран дүрслэл нуугдан үлдсэн байдгийг манай сэтгүүлчид уудлан гаргаж өнгөлөн зүлгэх мэт, нийтийн үг ярианд оруулж байвал үлэмж тустай биш үү.*

»

"Хуулийн төсөл боловсрогдоогүй тул их хуралд өргөгдөн баригдаагүй байгааг нээх (нэг их) ярихгүй байна ш дээ. Энэ дээр байнгын хороод анхаарч яригдаагүй байгаа зүйлийг тодруул. Энэ утгаар нь Засгийн газарт өшөө тодорхой даалгавар өгөгдөх байх. Асуудал шийдэгдэж, тогтоолд гарын үсэг зурагдтал хүлээх нь зүйтэй. Асуудал яагаад ийм байдгийм. Буруутай нөхдөд арга хэмжээ авахад яадгийм" гэсэн жишээнд 13 үг (налуу үсгээр бичсэн)-ийг онцлон "Амнаас нь нааштай ямар үг унах бол хэмээн ард түмэн чих тавин суудаг дарга нарын маань өдөр тутмын ярианы нэгэн хэсэг энэ дээ" гэж ёжлон шүүмжилсэн байна.

Бусдаар үйлдүүлэхийн идэвхгүй хэлбэрт дарга нар дуртай болсон нь асуудлыг өөрөөсөө зайлуулж бусдад нялзаах дуртай сэтгэлгээтэй нь холбоотой. "Тогтоолд гарын үсэг зуртал хүлээ" гээд шууд хэлж чадахгүй, тогтоол гэж нэг юманд тэнгэрээс ч юм уу, хаа нэг газраас гарын үсэг зурдаг, гагцхүү түүнийг л хүлээхээс өөр ямар ч арга байхгүйг учирлан улиглахдаа ийм байдалд оржээ. Үүнийг нь хэлний дархан хилийн цэрэг байх ёстой сэтгүүлчид тэр чигээр нь дамжуулсаар уянгаллаг сайхан хэлээ ядууруулсаар байна.

Олон нийтийн гэх сайхан тодотголтой, Үндэсний зөвлөлийг нь Ерөнхийлөгч, Их хурал, Засгийн газар, олон нийтийн байгууллагаас сүр дуулиантай сонгодог МҮОНРТВ ч мөн л яруу бус ядуу хэлтэй, дүрсэлгээний бус дүнхүү үгсээр ярьж бичсээр хэвшиж байна. Судлаач, хэлбичгийн ухааны доктор (Ph.D.) Б.Нацагдорж "МҮОНТ-ийн 2012 оны 3-р сарын 6-ны эфир "Эко ертөнц" нэвтрүүлгээр "Хууль бус модны наймаа" сэдвээр асуудал дэвшүүлж, цагдаагийн газрын байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй газрын

удирдлагууд оролцлоо. Тэд бүгд "Хууль бус модны наймаа" гэж яриад сэтгүүлч ч "өөрөө хууль бус модны наймаа" гэж давтаад байна. Зүй нь "модны хууль бус наймаа" гэвэл болох сон. Хууль бус мод юм бол авсан ч яахав гэж бодогдмоор... "Урвуу толь" нэвтрүүлгийн хөтлөгчийн үгэнд "Лаг их", "лайтай гоё", "надыг харж байхад" гэх мэт хар ярианы үгс дэндүү их байна"<sup>4</sup> гэх мэтээр олон жишээ баримт иш татжээ.

Реклам сурталчилгаа төлбөртэй, бусдын захиас өмч байдаг ч хэлний зүйн үүднээс зөв хэлбэршүүлэн засч болно. Хэдэн жилийн өмнө "Даатгагдсан хадгаламж, даатгагдсан ирээдүй" гэж үндэсний телевизээр хэчнээн улиглан давтав. Харин одоо намжсан нь сайшаалтай.

**С**этгүүлчид ийнхүү болхи толхи үгээр нэвтрүүлэг, нийтлэлээ бүтээж байхыг олон түмэн шүүжилдэг ч сайжрал заслыг олохгүй байна. Гэтэл жирийн малчин хүн уран гоё дүрслэлтэй өгүүлснийг тэмдэглэн авчээ. Хэдэн жилийн өмнө Өвөрхангай аймгийн Хужирт сумын Балбарын Дамдинсан "Өө энэ хотынхон хөдөө ирээд идээ, ундааны сайхныг ч мэдэхгүй, айрагны болсон, түүхийг ч ялгахгүй, хөөс цахарсан цагаан саамыг "аягүй гоё айраг, аймаар гоё байна" хэмээн гэдэс савныхаа хэмжээг ч мэдэхгүй учир зүггүй уугаад л, ууж дуусаагүй байж идэмхий үхэр шиг цаас шоржигнуулаад год үсрэн гараад л бутны цаанаас үсрэх гэж буй бүргэд шиг наашаа хараад суудаг. Тасархай дээлтэй юм болохоороо яаж ч цаашаа харах вэ дээ" гэж хэлж байжээ. Манай суурин газрын залуусын ахуй амьдралын мэдлэггүй, хөөрхийлэлтэй байдал хөдөөгийн малчин хүний ажигч гярхай нүдэнд ийнхүү харагдаж байна. Тэр

чигээрээ сурвалжлагын дүрслэл. Нүдэнд харагдаж, чихэнд сонсогдон, айраг үнэртэж, тасархай хувцастай залуусын хэцүү нэртийн дуу чимээ дуулдах мэт болж байна.

Монгол хэлээ хөгжүүлэх ардын хэлнийхээ яруу дүрслэлийг хадгалж үлдэхийн тулд бид юу хийх ёстой вэ? Хил хамгаалдаг цэргийнхэнд бага түрүүч, түрүүч, ахлах түрүүчээс хэлээд хошууч генерал, дэслэгч генерал, хурандаа генерал, армийн генерал цол олгодог байхад хэл хамгаалдаг бичгийн хүмүүст ямар цол өгдөг юм бэ?

**М**өн "Мал төрийн хамгаалалт байна" гэж Үндсэн хуулиар тунхагласан, мал малладаг малчдад сумын аварга, сумын хошой аварга, сумын мэнд сүрэгтэн, аймгийн аварга, улсын сайн малчин, баатар хоньчин цол хүртэл олгодог биз дээ. Гэтэл хэл хамгаалагч нарт... Дахиад л хоосон...

Ном бичигт зөв ханддаг монгол уламжлалаа эргэн нэг харъя. "Монгол номын редакторуудад Да гүүш, Билгийн далай, Номын далай, Билэгт гүүш, Номч гүүш, Үлэмж оюут гүүш, Хурц билэгт гүүш гэх мэт алдар цолыг хайрладаг байжээ..."<sup>5</sup> гэж эрдэмтэн Л.Норовсүрэн бичжээ. Яагаад ийм цол өргөмжлөл хүртээж болохгүй байхав.

Монгол хэлийг төрийн хамгаалалтад оруулж эх хэлээ хайрлан хамгаалагчдад зэрэг дэв олгож, "Чихнээ чимэг болсон аялгуу сайхан монгол хэлээ" гутаагчдад, тоглоом шоглоом болгон тохууран наадагчдад зэм шийтгэл хүлээлгэж байя. Цахим хэвлэл ч гэсэн

олон нийтэд зориулагдаж л байгаа юм бол хэлний дархан байдлын төлөө хариуцлага хүлээх ёстой.

### Ишлэл

<sup>1</sup> Дархад зоны түүхийн товчоон // "Маанар" сонин, 2002, №13.

<sup>2</sup> Хадбаатар Д. Тэмдэглэлийн дэвтэр ярьж байна // "Ням гариг" сонин, 1996.11.24, № 47.

<sup>3</sup> "Өнөөдөр" сонин, 2005.09.28, № 228 (2577).

<sup>4</sup> Нацагдорж Б. 2012. Телевизийн нийтлэл, нэвтрүүлгийн хэл найруулга, хэрэглээ соёлын зарим асуудал. УБ., 67, 95 дахь тал.

<sup>5</sup> Норовсүрэн Л. 2008. Хянан найруулах ухаан. УБ., 39 дэх тал.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Дархад зоны түүхийн товчоон // "Маанар" сонин, 2002, №13.

2. Нацагдорж Б. 2012. Телевизийн нийтлэл, нэвтрүүлгийн хэл найруулга, хэрэглээ соёлын зарим асуудал. УБ.

3. Норовсүрэн Л. 2008. Хянан найруулах ухаан. УБ.

4. "Өнөөдөр" сонин, 2005.09.28, № 228 (2577).

5. Хадбаатар Д. Тэмдэглэлийн дэвтэр ярьж байна // "Ням гариг" сонин, 1996.11.24.

### Summary

This article proposes an idea to award academics with titles of ancient sages such as Da Guush, Nomch Guush, Nomiin Dalai, Bilgiin Dalai for their life time achievement in protecting our native language and teaching its melodious speaking style to journalists and amateur writers.